



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/549

Эрдэнэт


Г Улсын асрамжинд явуулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./д/, 29.2, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1, 19.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Асран хамгаалах үр хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй, хөгжлийн бэрхшээлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн иргэн Санжаагийн Болдыг Хөвсгөл аймаг дахь асрамжийн газарт, мөн багийн иргэн Цогбадрахын Чимэддагвыг Төв аймгийн Батсүмбэрийн ахмадын асрамжинд 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн шилжүүлэн асрамжлуулахыг зөвшөөрсүгэй.

2.Улсын асрамжийн газарт хүргэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталж, иргэн С.Болд, Ц.Чимэддагва нарыг зохих журмын дагуу хүргэж өгөхийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар /н.Эрдэнэбат/-т даалгасугай.

3.Зардалд шаардагдах 195100 төгрөгийг /Нэг зуун ерэн таван мянга нэг зуун / төгрөгийг хуваарилагдаагүй бусад зардлын "Ахмад настны сар шинийн хүндэтгэл, нийгмийн халамжийн зөвлөлийн арга хэмжээний зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
10 дугаар сарын 03-ны өдрийн
А/579 дугаар захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын зүйл	Явах км	Шатахуун /литр/	Нийт дүн
1	Шатахуун /Эрдэнэтээс Батсүмбэр Батсүмбэрээс Эрдэнэт/	940	94x1650=155.1	155100
2	Бусад	2	20000	40000
Нийт зардал				195100

00



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/580

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эмч” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын улсын гуравдугаар төв эмнэлгийн Харвалт, Зүрхний шигдээсийн тасаг, Хавдар судлалын үндэсний төвийн Хөнгөвчлөх эмчилгээ үйлчилгээ, яаралтай тусламжийн тасаг зэрэг газруудад туршлага судлах, сэлгэн ажиллах, сургалтанд хамрагдах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 9900000 /Есөн сая есөн зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын 2017 оны “Хуваарилалт хийх тухай” А/306 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Зөвлөх эмч, нарийн мэргэжлийн эмч, сувилагч урилгаар түр ажил мэргэжлийн туршлага солилцох ажлын байр сэлгэн ажиллахад дэмжлэг үзүүлэх” зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /н.Баттүвшин/, Бүсийн оношлогоо эмчилгээний төв /н.Батсүх/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ